

## ХАЙГУУЛЧИН СЭТГҮҮЛ

### *Сэтгүүлийн товч түүхээс*

Түлш, эрчим хүчний үйлдвэр, геологийн (1976 он хүртэл) ба Геологи, уул уурхайн үйлдвэрийн (1976 оноос) яамны үйлдвэрлэл-эрдэм шинжилгээний “ХАЙГУУЛЧИН” сэтгүүл 1972 оны IV улирлаас 1983 оны I улирал хүртэл нийт 42 дугаар, 2600 хүртэл хувиар, 6,5 хүртэл хэвлэлийн хуудас хэмжээтэйгээр хэвлэгдэж, геологчдын төв хэвлэлийн үүрэг гүйцэтгэж байлаа.

Тухайн үед “Хайгуулчин” сэтгүүлийн ерөнхий эрхлэгчээр Ч.Хурц, Г.Дорж, З.Барас, хариуцлагатай нарийн бичгийн даргаар Я.Нархүү, Л.Батмөнх, З.Нарангэрэл, Ө.Жамьяндорж нар, зөвлөлийн гишүүдээр С.Аюур, Ж.Бямба, Р.Барсболд, А.Гүррагчаа, С.Дашдаваа, Г.Доржрэнчин, З.Нарангэрэл, Ш.Сономцэрэн, Н.Тогооч, В.Уртнасан, Г.Дорж, Ц.Сэджав, Л.Эвийхүү, Ц.Самбалхүндэв, Д.Доржнамжаа нар ажиллаж байсан байна. 1972-1983 оны хооронд “Хайгуулчин” сэтгүүлд 800 гаруй зохиогчийн геологийн судалгааны шинэлэг үр дүн, арга аргачлал, сурталчилгааны 700 гаруй өгүүлэл нийтлэгдэж геологчдод цаг үеийн төр засгийн бодлого, шинэ нээлт, геологи хайгуулын ажлын арга аргачлал болон бусад мэдээллийг уламжилж ирсэн түүхтэй

### *Өнөөгийн бодит байдал*

“Монголын Үйлдвэрлэлийн геологчид” холбооноос санаачлан 1983 оны 2-р улирлаас эхлэн тасраад байсан “Хайгуулчин” сэтгүүлийг сэргээн хэвлүүлж эрдэс баялгийн салбарынхны төв хэвлэл болгох зорилт тавин 27 жилийн дараа дахин сэргээж 2010 оны 3 сард зохион байгуулсан MMER-2010 чуулга уулзалтын үеэр хэвлүүлэн геологчдын хүртээл болсон билээ.

“Хайгуулчин” сэтгүүлийг олон жил нэр хүндтэй авч явсан өмнөх үеэ хүндэтгэж, уламжлалаа хадгалах үүднээс сэтгүүлийн нүүр, эмблемийг хуучин хэвээр нь үлдээж, дугаарыг мөн 1983 онд хэвлэгдсэн хамгийн сүүлчийн дугаараас үргэлжлүүлэн дугаарлаж шинэ агуулгаар баяжуулан, шинэлэг мэдээллийг цаг алдалгүй геологчиддоо хүргэн ажиллаж байна.

“Хайгуулчин” сэтгүүлд Монгол орны геологи, ашигт малтмалын судалгааны талаарх төр засгийн бодлого, шийдвэр, ажлын бодит үр дүн, шинэ арга аргачлал, техник-технологи, танин мэдэхүй, мэргэжилтний санал бодол, танин мэдэхүй, мэдээлэл сурталчилгаа зэрэг өргөн хүрээтэй материалууд нийтлэгдэх болно.

2010 оноос өнөөдрийг хүртэл тус сэтгүүлийн нийт долоон дугаар гаргаад байгаа бөгөөд эдгээрээс дөрвөн дугаарыг жил бүрийн 3-р сард зохион байгуулагддаг Монголын геологи хайгуул чуулга уулзалтанд зориулан хэвлүүлжээ. Энэ жил зохион байгуулагдах Монголын геологи, хайгуул 2014 чуулга уулзалтын 6 жилийн ойд зориулж “ХАЙГУУЛЧИН” сэтгүүлийн 50 дахь дугаар хэвлэгдэн гарах гэж байна.

№	Сэтгүүлийн дугаар	Зориулалт	Хэвлэгдсэн он
1	Хайгуулчин-43	Монгол орны геологи, ашигт малтмалын хайгуул чуулга уулзалт. “Roundup-2010”	2010
2	Хайгуулчин-44/1	Монгол орны геологи, ашигт малтмалын хайгуул чуулга уулзалт. “Roundup-2011”	2011
3	Хайгуулчин-44/2	Монголын геологийн алба үүсгэн байгуулагдсаны 72 жилийн ой	2011
4	Хайгуулчин-46	Монгол орны геологи, ашигт малтмалын хайгуул чуулга уулзалт. “Roundup-2012”	2012
5	Хайгуулчин-47	Монголын геологийн алба үүсгэн байгуулагдсаны 73 жилийн ой, доктор Ж.Ган-Очирын 70 насны ойд	2012
6	Хайгуулчин-48	Монгол орны геологи, ашигт малтмалын хайгуул чуулга уулзалт. “Roundup-2013”	2013
7	Хайгуулчин-49	Монголын геологийн алба үүсгэн байгуулагдсаны 74 жилийн ойд	2013

### *Хэтийн чиг хандлага*

“Хайгуулчин” сэтгүүлийг илүү сайжруулан чанартай мэдээллээр хангахад зөвхөн редакцийн зөвлөлийн гишүүдийн бус Монголын нийт геологчид та бүхний судалгаа, санал, мэдээлэл чухал үүрэгтэй билээ.

Монгол орон нь региональ геологийн тогтоцын хувьд Төв Азийн атираат бүсийн төвд оршдоогоороо гадаадын олон орны эрдэмтэд судлаачдын анхаарлын төвд байсаар ирсэн билээ. Монгол орны геологи, геодинамик, металлогенийг нарийвчлан судалсанаар Төв Азийн атираат тогтолцоо бүрэлдэн тогтсон геологийн хөгжлийг сэргээн босгоход үнэтэй хувь нэмэртэй юм. Иймд Монгол орныхоо геологийн тогтоцын талаар өчүүхэн ч гэсэн мэдээллийг дэлхий дахинд цацах, улмаар олон улсын хамтарсан судалгааг өрнүүлэхэд “ХАЙГУУЛЧИН” сэтгүүлд өөрийн хувь нэмэр оруулахыг нийт геологчиддоо уриалж байна.